



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



гуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	7
2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар.....	8
2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	9
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал.....	12
3.2 Батлагдсан орон тоотой холбоотой асуудал.....	12
3.3 Төсөл хөтөлбөрийн нэгжүүдтэй холбоотой асуудал.....	13
3.4 Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй холбоотой асуудал.....	13
4. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж



САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.05.03 № 964
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



Аудитын тайлан

2.1. Оршил

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Ч.Хүрэлбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн харьяа байгууллагуудын төсвийн хуваарийг баталгаажуулж байх, дууссан төсөл хөтөлбөрийн нэгжүүдийн хаалтын тайланг гаргаж байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-т заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 2019 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 5 дугаар сарын 5-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Сэржмядаг, Б.Уянга, Г.Мөнхчимэг нар гүйцэтгэв.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 11-2/2246 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБООУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сангийн яамны талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан болно.

Сангийн яамны тэргүүлэх байр суурь, нэр хүндийг улам бэхжүүлэх хүрээнд “2018 оныг Яамны сахилга хариуцлагыг сайжруулах жил” болгох зорилт дэвшүүлж ажилласан бөгөөд тайлант хугацаанд 250 гаруй арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 97.2 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Сангийн сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд холбогдох хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудад нэмэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Сангийн яам төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

Санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.



Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу харьяа 6 байгууллагад дотоод аудит хийж, 8,850.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, давхардсан тоогоор 135 зөвлөмж өгсөн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 19 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,822,443.4 сая төгрөгийн 2.0 хувь буюу 56,448.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтээр дахин тооцоход нийт зардал 2,568,416.2 сая төгрөгийн 2 хувь буюу 51,368.3 сая төгрөг байна.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2.0 хувиар тооцсон нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй, эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 90 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 78 санхүүгийн тайлан аудитад хамрагдаж, 5 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, зээлийн ашиглалт гараагүй 6 төсөл, хөтөлбөр болон дуудлага худалдаанд зарлагдсан үйл ажиллагаа явуулаагүй 1 төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллага аудитад хамрагдаагүй байна.



үснэгт 1. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр.

/тоогоор/

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	44	4	5	
2	Төрийн өмчит үйлдвэрийн газар	10			1
3	Төсөл хэрэгжүүлэх нэгж	12	1		6
4	Засгийн газрын тусгай сан	1	3		
5	Төсвийн төвлөрүүлэн захирагч	2			
6	Төсвийн ерөнхийлөн захирагч	1			
Дүн		70	8	5	7

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/156 дугаар тушаал

Аудитаар 66 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 4 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” өгсөн байна. Үүнд:

Хүснэгт 1. Хязгаарлалттай дүгнэлт өгсөн байгууллага

№	Байгууллагын нэр	Хязгаарлалтын үндэслэл
1	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК	Үнэт цаас өмчлөгчдийн зөвшөөрөлгүй харилцах данс дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хадгаламжид байршуулж хүүгийн орлого олсон
2	Хан-Уул дүүргийн татварын хэлтэс	Дүүргийн төсвөөс олгосон орон тооны бус байцаагч нарыг ажиллуулах зардлаас 30.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 5.4 сая төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй, 3.0 сая төгрөгийн хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн
3	Налайх дүүргийн татварын хэлтэс	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын комисс нь бараа материалын тооллого, шатахууны зарцуулалтын тооцоог холбогдох заавар, журмын дагуу бодоогүй, хяналт сул, замын хуудсыг бүрэн бөглөөгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн зэрэг 261.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн
4	Баянзүрх дүүргийн татварын хэлтэс	Дүүргийн төсвөөс олгосон татвар хураалт, орлого бүрдүүлэлтэд зарцуулах зардлаас /орон тооны бус байцаагч нарыг ажиллуулах зардал/ 107.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 20.5 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрсөн.

Эх сурвалж: 2018 оны Аудитын тайлан

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 159,791.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 99.0 хувь буюу 158,127.7 сая төгрөгийн 52 нягтлан бодох бүртгэлийн алдааг аудитын явцад залруулж, 32.0 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 0.2 хувь буюу 381.2 сая төгрөгийн 13 зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 0.8 хувь буюу 1,250.1 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх 94 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг төсвийн захирагчаар нь дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2. Алдаа, зөрчил, түүний шийдвэрлэлт.

/сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
1	Төсвийн шууд захирагч	2	19.1					2	19.1
2	Төрийн өмчит үйлдвэрийн газар	26	714.8			1		25	714.8
3	Төсөл хэрэгжүүлэх нэгж	8	67.2					8	67.2
4	Засгийн газрын тусгай сан	-	-						
5	Төсвийн төвлөрүүлэн захирагч	77	776.3	10	32.0	12	381.2	55	363.1
6	Төсвийн ерөнхийлөн захирагч	4	85.9					4	85.9
Дүн		117	1,663.3	10	32.0	13	381.2	94	1,250.1

Эх сурвалж: 2018 оны Аудит хийсэн санхүүгийн тайлан

8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа зөрчлөөс материаллаг алдаа зөрчлийг дурдвал:

Төрийн банк: Эрсдэлийн удирдлагын тодруулгын хэсэг дэх төлбөрийн чанарын хэсэг материаллаг алдаатай байгааг аудитаар авч үзэж байна. Тухайлбал гэрээний хугацаанд суурилсан ирээдүйн авлага болон өглөг, хүүгийн өглөг зэрэг гэрээний хугацааг хамрах бүх дүнг бүрэн бөгөөд үнэн зөв багтаагаагүй байсан. Банкнаас анх танилцуулсан ирээдүйн төлбөрийн чадварын тоон мэдээлэл үнэн зөв байгаагүй бөгөөд энэ нь Банкны төлбөрийн чадварын үзүүлэлтийн өгөгдлийн удирдлага болон түүний хяналт дээр асуудал байж болзошгүйг илтгэж байна.

Монголын Хөрөнгийн бирж ТӨХК: Тус компани 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлант жилд компанийн богино хугацаат өр төлбөр нь эргэлтийн хөрөнгийн дүнгээс 27.3 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн ба компани нь 1,259.8 сая төгрөгийн цэвэр алдагдалтай байна. Энэхүү алдагдал болон богино хугацаат өр төлбөр нь Миллениум Ай Ти системийн ашиглалтын зардалтай холбоотой бөгөөд энэхүү зардлыг Үнэт Цаасны Хадгаламжийн Төв болон арилжаа төлбөр тооцооны газрууд хуваан төлөх төлөвлөгөөг цаг алдалгүй амжилттай хэрэгжүүлээгүй тохиолдолд байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд нөлөө үзүүлж болзошгүй ба ийм тохиолдолд Монголын Хөрөнгийн бирж нь хувьцаа эзэмшигчээс нэмэлт санхүүжилтийг авах шаардлага гарах магадлалтай байна.

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК: Газар тариалангийн даатгалын нөөц сан нь нөхөн хүрэлцээгүйтэй холбоотойгоор 2018 онд хуримтлагдсан ашгаас 54.8 сая төгрөгийн нөөцийг байгуулж бусад орлогоор бүртгэсэн нь хэдийгээр Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 70 дугаар тогтоолын дагуу батлагдсан "Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-тай нийцэж байгаа боловч СТОУС 4-ийн дагуу компани тухайн жилд гарсан нөхөн төлбөрийг тухайн жилийн ашиг, алдагдлаар бүртгэнэ гэсэнтэй зөрчилдсөн байна.

Тус компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар Монголын Улаан Загалмай Нийгэмлэгт 50.0 сая төгрөгийн хандив өгсөн байна.

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК: Төсвийн тухай хуульд заасны дагуу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон аудитын тайланг Үндэсний аудитын газарт ирүүлээгүй. Аудит гүйцэтгэх гэрээний хугацааг хуульд нийцүүлэн байгуулаагүйгээс аудитаар илэрсэн асуудлын талаарх байгууллагын удирдлагад хүргүүлсэн удирдлагын захидал гараагүй.

Хадгаламж даатгалын корпорацн ХХК: Төсвийн тухай хуульд заасны дагуу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон аудитын тайланг Үндэсний аудитын газарт ирүүлээгүй. Аудит гүйцэтгэх гэрээний хугацааг хуульд нийцүүлэн байгуулаагүйгээс аудитаар илэрсэн асуудлын талаарх байгууллагын удирдлагад хүргүүлсэн удирдлагын захидал гараагүй.

Зээлийн батлан даалтын сан: Сангийн Удирдах зөвлөл 2018 оны үйл ажиллагааны зардлын төсвийг батлахдаа үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа 15 хувиас хэтрэхгүй байх гэсэн заалтыг мөрдөөгүй 21.2 хувиар баталсан, мөн орлогын дэлгэрэнгүй тайлангийн үйл ажиллагааны зардлын дүнг өөрийн хөрөнгөнд харьцуулахад үйл ажиллагааны зардлын зохистой харьцааны үзүүлэлт 20.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.



атварын ерөнхий газар: Сангийн сайдын 2016 оны 301 дүгээр тушаалаар Татварын ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг нийт 1823 байхаар баталсан боловч 2017 онд 88, 2018 онд 76 орон тоогоор тус тус хэтрүүлэн ажилласан.

Гаалийн ерөнхий газар: Хураагдсан болон улсын орлого болгох барааг борлуулж улсын төсвийн орлого болгох ажил удаашралтай байна.

Татварын болон гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагууд

- Өмнөх оны аудитаар тогтоосон актыг төсвөөс төлсөн, анхан шатны нотлох баримтгүй зардал гаргасан, шатахууны зардал баримтаар нотлогдоогүй, ээлжийн амралтыг давхардуулан цалин олгосон гэх зэрэг 32.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. /Татварын ерөнхий газрын харьяа 4 байгууллага 6.5 сая, Гаалийн ерөнхий газрын харьяа 6 байгууллага 25.5 сая төгрөг/
- Тооцоо нийлсэн актгүй он удаан жил болсон авлага санхүүгийн тайланд бүртгэлтэй, бараа материалын тайлан гаргаагүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэсэн, шүүхийн шийдвэрийн нэхэмжлэлийг төсвөөс төлсөн, үндсэн хөрөнгийг дансанд тусгаагүй, шатахууны зардлын холбогдох тооцоог хийгээгүй, төсвийн хөрөнгийг баяр ёслолын арга хэмжээнд зарцуулсан, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, томилолтын зардлын анхан шатны баримт дутуу зэрэг нийт 381.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн байна. /Татварын ерөнхий газрын харьяа 7 байгууллага 275.2 сая, Гаалийн ерөнхий газрын харьяа 4 байгууллага 106.0 сая төгрөг/

2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцов.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх 4 асуудлыг Менежментийн захидалд тусгалаа.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүгийн хяналт тавьж үнэлэх журам”-ын жишиг цалин, ажлын хөлсийг тогтоох үнэлгээний шалгуур, хөлсөөр ажиллах гэрээ, хүүгийн орлогын зарцуулалт зэрэг нь холбогдох хууль, тогтоомжтой зөрчилдөж байгаа тул тус журмыг шинэчлэх, зөвлөмжийн биелэлт бүрэн хэрэгжээгүй төслийн шатандаа байна. Мөн журмын төсөлтэй танилцахад цалин хөлс олгох, хүүгийн орлогын зарцуулалт, тайлагнал, төсөл дуусвар болоход төслийн санхүүжилтийн үлдэгдлийг хэрхэн шийдвэрлэх болон хаалтын тайланг гаргаагүй, үлдэгдэл хөрөнгийг журмын дагуу шийдвэрлээгүйд хүлээлгэх хариуцлага зэргийг нарийвчлан тусгаж өгөөгүй, өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийг хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь анхаарал хандуулах асуудал болж байна.

10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд зааснаар Сангийн сайдын харьяа байгууллагууд 4,669,220.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдаж гүйцэтгэлээр 6,389,835.9 сая төгрөг бүрдүүлж 36.9 хувиар давуулсан байна.

Хүснэгт 3. Төвлөрүүлэх орлого				/сая төгрөг/	
Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
Татварын ерөнхий газар	2,375,776.2	3,558,725.6	1,182,949.4	149.8	
Үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд	122,747.2	206,986.6	84,239.4	168.6	
Ирээдүйн өв санд	460,901.8	588,606.0	127,704.2	127.7	
Гаалийн ерөнхий газар	2,194,165.1	2,732,299.6	538,134.5	124.5	
Сангийн яам	13,229.3	21,949.4	8,720.1	165.9	
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	71,559.7	60,270.8	-11,288.9	84.2	
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	10,916.7	3,320.4	-7,596.3	30.4	
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,573.5	13,270.1	9,696.6	371.3	
Дүн	4,669,220.5	6,389,835.9	1,720,615.4	136.9	

Эх сурвалж: 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 1,789,596.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,572,343.0 сая төгрөгийг урсгал зардалд, 87,023.6 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд, 130,230.0 сая төгрөгийг гадаад төслийн зээл болон эргэн төлөгдөх зээлийн эх үүсвэрээр санхүүжигдэх зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 94 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 32,810.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 20,786.3 сая төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,604,253.2 сая төгрөг буюу 89.6 хувьтай байгаа нь зарим төсөвлөсөн төсөл хөтөлбөрийн нэгжүүдийн ашиглалт гараагүй, дүрмийн санг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт хийгдээгүй зэрэгтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтээр хандив тусламжаар 120.6 сая, Засгийн газрын нөөц сан болон Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,868.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 1,614.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 241.0 сая, нийт 4,845.0 сая төгрөгийн орлого бүрдсэнээс 3,806.9 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 1,038.1 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Цахим хуудсанд 2018 оны 17 төрлийн тайлан, мэдээг бүрэн байршуулсан байна.



.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмжийн хэрэгжилт 90 хувийн биелэлттэй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сангийн сайдын эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдсан.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа байгууллагуудын төсвийн хуваарийг баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид харьяа байгууллагуудын төсвийн хуваарийг баталгаажуулж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр гарын үсэг зуруулж, баталгаажуулсан болно.

3.2 Батлагдсан орон тоотой холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Татварын ерөнхий газар болон харьяа хэлтэс, нэгжүүдэд батлагдсан орон тооноос илүү 48 албан хаагч ажиллаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12-т “Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн

авхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох” заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийг үрэлгэн зарцуулах, хууль тогтоомжийг мөрдөж ажиллахгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Татварын ерөнхий газар болон харьяа хэлтэс, нэгжүүдэд шаардлагатай орон тоо байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийж орон тоог эцэслэн тогтоох

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр гарын үсэг зуруулж, баталгаажуулсан болно.

3.3 Төсөл хөтөлбөрийн нэгжүүдтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Дууссан төсөл, арга хэмжээний хаалтын тайлан гаргаагүй, 85.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлээгүй, зарим хөрөнгийн элэгдэл тооцоогүй, санхүүгийн тайлан гаргаагүй, эхний үлдэгдлээр төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэсэн нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүгийн хяналт тавьж үнэлэх журам”-ын 26.5-д “Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн эцсийн тайланг энэхүү журмын 12 дугаар хавсралтын дагуу боловсруулж, санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлж, удирдлагын мэдээллийн системд оруулах бөгөөд төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө алдагдах, шамшигдах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Дууссан төсөл, арга хэмжээний хаалтын санхүүгийн тайлан гаргах, үндсэн хөрөнгийг холбогдох журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлэх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр гарын үсэг зуруулж, баталгаажуулсан болно.

3.4 Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг Монгол Улсын Хөгжлийн банк ХХК, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК, Хадгаламж даатгалын корпораци ХХК, Төрийн банк ХХК 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн



